



СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 11 сарын 10 өдөр

Дугаар 134

Сүхбаатар сум


Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12, Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 3 дахь хэсгийн "а", "в" заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас олгох шагналын журам"-ыг 1 дүгээр хавсралтаар, шагналын шалгуур үзүүлэлтийг 2 дугаар хавсралтаар, шагналуудыг дагалдах зүйлс, олгох мөнгөн шагналын хэмжээг 3 дугаар хавсралтаар, шагналын анкетыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. "Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас олгох шагналын журам"-ыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусган батлуулж ажиллахыг аймгийн Засаг дарга Ш.Оргил-д даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн "Сэлэнгэ аймгийн Хүндэт иргэн өргөмжлөл бий болгох тухай" 1997 оны 72 дугаар тогтоолын хавсралт, "Аймгийн Хүндэт тэмдэг бий болгох тухай" 2011 оны 16 дугаар тогтоолын хавсралт, "Шагналын журмыг шинэчлэн батлах тухай" 2014 оны 81 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 11 дүгээр сарын 10-ны
өдрийн 134 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

TTCS7446 9055003

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГААС ОЛГОХ ШАГНАЛЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Аймгийнхаа хөгжил дэвшилийн төлөө хөдөлмөр бүтээлээ зориулан ажил үйлс, авьяас билэг, эрдэм ухаанаараа шалгарсан хамт олон, ажилтан, иргэнийг аймгийн ИТХ, Засаг даргаас шагнаж урамшуулах харилцааг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Шагналын төрөл

2.1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгох шагнал нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуупийн 20.1.12 дахь заалтад заасны дагуу дор дурдсан төрөлтэй байна.

- а/ Аймгийн "Хүндэт иргэн"
- б/ Аймгийн алдартнуудын "Нэрэмжит шагнал"
- в/ Аймгийн "Хүндэт тэмдэг"
- г/ Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Хүндэт өргөмжлөл"

2.2 Энэ журмын 2.1-ийн "б"-д заасан "Нэрэмжит шагнал"-үүд нь Сэлэнгэ аймгаас төрөн гарсан дор дурьдсан алдартан, гавьяат зүтгэлтнүүдийн нэрэмжит байна. Үүнд:

- а/ Ардын хувьсгалын партизан, БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн анхны дарга Г.Бумцэндийн нэрэмжит шагналаар Төрийн жинхэнэ албан хаагчийг;
- б/ Монгол Улсын төрийн шагналт, эрдэмтэн зохиолч, академич Б.Ренчингийн нэрэмжит шагналаар Боловсролын салбарын ажилтныг;
- в/ Монгол Улсын Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан, академич П.Нямдаваагийн нэрэмжит шагналаар Эрүүл мэндийн салбарын ажилтныг;
- г/ Монгол Улсын ардын жүжигчин П.Цэрэндагвын нэрэмжит шагналаар соёл урлагийн салбарын ажилтныг;
- д/ Монгол Улсын гавьяат тамирчин, Олимп, дэлхийн аваргын хүрэл медальт Д.Оюунболдын нэрэмжит шагналаар Биеийн тамир, спортын салбарын ажилтныг;
- е/ Монгол Улсын хөдөлмөрийн баатар О.Дорлигсүрэнгийн нэрэмжит шагналаар Худалдаа, үйлдвэрлэл /жижиг, дунд үйлдвэрлэл, нийтийн ахуйн үйлчилгээ эрхлэгчид/-ийн салбарын ажилтныг;
- ё/ Монгол Улсын хөдөлмөрийн баатар, хүндэт төмөр замчин Ц.Чойжилын нэрэмжит шагналаар дэд бүтцийн салбарын ажилтныг;
- ж/ Монгол Улсын ууган хөдөлмөрийн баатар Н.Бямбацогтын нэрэмжит шагналаар газар тариалангийн салбарын ажилтныг;
- з/ Монгол Улсын хөдөлмөрийн баатар Ш.Дагвадоржийн нэрэмжит шагналаар мал аж ахуйн салбарын ажилтан, малчныг;

2.3."Нэрэмжит шагнал"-ын төрлийг нэмэх, өөрчлөх асуудлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

2.4.Аймгийн Засаг даргаас олгох шагналууд нь Засгийн газрын "Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай" 1997 оны 54 дүгээр тогтоолын 1 дэх заалтыг үндэслэн дор дурдсан төрөлтэй байна.

- а/ Аймгийн Засаг даргын "Жуух бичиг"
- б/ Аймгийн "Тэргүүний хамт олон"
- в/ Аймгийн "Аварга ажилтан"
- г/ Аймгийн "Аварга малчин"
- д/ Аймгийн "Аварга фермер"
- е/ Аймгийн "Аварга тариаланч хамт олон"
- ё/ Аймгийн "Аварга тариаланч"
- ж/ Аймгийн "Аварга ногоочин"
- з/ Аймгийн "Шилдэг уяач"
- и/ Аймгийн "Тэргүүний сурагч"

2.5.Энэ журмын 2.4-ийн "в"-д заасан шагналаар дараах салбарт ажиллагсдаас тус бүр нэг ажилтньг шалгаруулан шагнана. Үүнд:

а/ Төрийн захиргааны аварга ажилтан /нийгмийн халамж, нийгмийн даатгал, мэргэжлийн хяналтын байгууллага/;

б/ Боловсролын салбарын аварга ажилтан;
в/Эрүүл мэндийн салбарын аварга ажилтан;
г/ Соёл урлагийн салбарын аварга ажилтан;
д/ Биеийн тамир, спортын салбарын аварга ажилтан;
е/ Санхүү, эдийн засаг /санхүүгийн хяналт/-ийн салбарын аварга ажилтан;
ё/ Худалдаа, үйлчилгээ /нийтийн хоол, бөөний болон жижиглэн худалдаа эрхлэгч/-ний салбарын аварга ажилтан;

ж/ Үйлдвэрлэл /жижиг, дунд үйлдвэрлэл, нийтийн ахуйн үйлчилгээ эрхлэгчид/-ийн салбарын аварга ажилтан;

з/ Дэд бүтэц /зам тээвэр, эрчим хүч, барилга, холбоо/-ийн салбарын аварга ажилтан:

- и/ Хууль хяналтын салбарын аварга ажилтан;
- й/ Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын аварга ажилтан;

2.5. "Тэргүүний сурагч"-аар сурлага, урлаг, спортын гэсэн төрлөөр тус бүр нэг сурагчийг шалгаруулан шагнана.

2.6. Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, ардын болон гавьяат цолоор шагнагдсан Сэлэнгэ аймгийн харьят болон тус аймагт амьдарч ажил хөдөлмөр эрхэлж байгаа иргэнд шагнал, мөнгөн урамшуулал олгож болно.

2.7 Монгол Улсаа төлөөлөн олимп, тив, дэлхийн хэмжээний болон олон улсын "А" зэрэглэлийн тэмцээнд амжилттай оролцож медаль хүртсэн, үндэсний спортоор өндөр амжилт гаргасан Сэлэнгэ аймгийн харьят иргэнд мөнгөн шагнал урамшуулал олгож болно.

Гурав. Шагналд нэр дэвшүүлэх, тодорхойлох

3.1. Аймгийн "Хүндэт иргэн"-ээр өргөмжлөх иргэнийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч, аймгийн Засаг дарга нар, аймгийн "Хүндэт"

тэмдэг"-ээр болон ИТХ-ын "Хүндэт өргөмжлөл"-өөр шагнуулах иргэнийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч, төлөөлөгч, аймгийн Засаг дарга, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, аж ахуйн нэгжийн дарга, захирал нар энэ журамд нийцүүлэн тодорхойлно.

3.2 Алдартнуудын "Нэрэмжит шагнал"-ыг тухайн салбарыг хариуцсан төрийн захиргааны байгууллага, хэлтэс, газруудын саналыг үндэслэн аймгийн Засаг дарга тодорхойлно. "Нэрэмжит шагнал"-ын шалгуур үзүүлэлтийг аймгийн Засаг даргын захирамжаар тогтоосно.

3.3. Аймгийн Засаг даргаас олгох шагналаар шагнуулах иргэдийг сумын Засаг дарга, байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлага тодорхойлно.

3.4. Аймгийн аварга хамт олон, ажилтан, тэргүүний сурагчийн шагналд нэр дэвшигчийн материалыг жил бүрийн 01 дүгээр сарын 05-ны дотор сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ.

3.5. Аймгийн аварга малчин, тариаланч хамт олон, тариаланч, ногоочин, фермер шагналд нэр дэвшигчийн материалыг жил бүрийн 01 дүгээр сарын 05-ны дотор сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн аймгийн Хүнс, хэдөө аж ахуйн асуудал эрхэлсэн байгууллагад ирүүлнэ.

3.6. Аймгийн шилдэг уяачид нэр дэвшигчийн материалыг жил бүрийн 01 дүгээр сарын 05-ны дотор сумын Морин спорт, уяачдын холбооны хурлаар хэлэлцүүлэн аймгийн Морин спорт, уяачдын холбоонд ирүүлнэ.

3.7. Энэ журмын 2.6, 2.7-д заасан шагнал урамшуулалт олгох иргэнийг тухайн салбарын холбогдох байгууллага, мэргэжлийн холбоод тодорхойлж аймгийн Засаг даргад уламжлан шийдвэрлүүлнэ.

3.6. Шагналд нэр дэвшсэн хүмүүсийг тодорхойлоходоо дор дурьдсан материалыг бүрдүүлсэн байна. Үүнд:

3.6.1. Батлагдсан загварын анкет /3х4 харьцаатай гэрэл зураг/.

3.6.2. Ажил байдлын тодорхойлолт.

3.6.3. Тодорхойлсон байгууллага, хамт олны хурлын тэмдэглэл

3.6.4. Шагнуулах тухай эрх бүхий албан тушаалтны гарын үсэг бүхий албан бичиг.

3.6.5. Онцгой амжилт гаргасан бол түүнийг гэрчлэх баримт бичиг, шийдвэрийн хуулбар.

3.8. Энэ журамд заасан шагналын материалыг хугацаа хожимдуулсан, материалын бүрдлийг дутуу ирүүлсэн тохиолдолд тодорхойлсон байгууллагад буцаана.

Дөрөв. Шагналыг шийдвэрлэх, олгох

4.1. Аймгийн "Хүндэт иргэн", "Нэрэмжит шагнал", "Хүндэт тэмдэг"-ээр шагнах асуудлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар, ИТХ-ын "Хүндэт өргөмжлөл"-өөр шагнах асуудлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын захирамжаар тус тус шийдвэрлэнэ.

4.2. Журмын 4.1-д заасан шагналын материалыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба бүрдлийг шалган хүлээн авч аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурал, Хурлын даргад танилцуулж шийдвэрлүүлнэ.

4.3. Журмын 2.4-ийн "а", 2.6, 2.7-д заасан шагнал, урамшууллыг аймгийн Засаг дарга тухай бүр захирамж гарган шийдвэрлэх бөгөөд журмын 2.4-д заасан бусад шагналыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны шийдвэрийг үндэслэн аймгийн Засаг дарга захирамж гарган жилд 1 удаа олгоно.

4.4. Аймгийн Засаг дарга Хуралд уламжлан тодорхойлж шийдвэрлүүлэх болоч Засаг даргын захирамжаар олгох шагналуудын материалыг Засаг даргын Тамгын газар хүлээн авч, энэ журмын дагуу судалж танилцан санаалаа боловсруулж аймгийн Засаг даргад танилцуулна.

4.6. Энэ журмын 2.1-ийн "в", "г"-д зааснаас бусад шагналын зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гарган шийдвэрлэнэ.

4.7. Энэ журмын 2.1, 2.2-ын "а"-д заасан шагналуудыг Үндэсний их баяр наадам, Цагаан сар, Улс тунхагласны өдөр, Мэргэжлийн байгууллага, ажилтны өдөр, хууль тогтоомжид заасан бусад тэмдэглэлт өдрөөр олгоно. Бусад тохиолдолд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэрээр олгож болно. Салбарын аваргыг жилд нэг удаа тодруулж, шагналыг дараа оны 1 дүгээр улиралд багтаан олгоно.

4.8. Шагналыг аймгийн удирдлагууд хүндэтгэлтэйгээр гардуулах бөгөөд шагнасан тухай шийдвэрийн хуулбарыг тодорхойлсон байгууллагад албан ёсоор хүлээлгэн өгнө.

4.9. Шагналын тэмдэг, үнэмлэхийг гээгдүүлсэн тохиолдолд нэг удаа нөхөн олгож болно. Нөхөж олгоходоо дараах материалыг бүрдүүлнэ.

4.9.1 Нөхөж олгохыг хүссэн өргөдөл.

4.9.2 Үрэгдүүлсэн талаар зарлуулсан баримт.

4.9.3 Тэмдэг гээгдүүлсэн бол үнэмлэхний хуулбар.

4.9.4 Мөнгө тушаасан баримт

Тав. Шагналын мэдээллийн сан

5.1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас олгосон шагналын талаарх бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх, сангийн хөдөлгөөн, баяжуулалтыг аймгийн Засаг даргын Тамгын газар хариуцна.

—оOо—

Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 11 дүгээр сарын 10-ны
өдрийн 134 дүээр тогтоодын 2 дугаар хавсралт

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУВАЛ ЗАСАГ ДАРГААС ОЛГОХ ШАГНАЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Шагналын нэр, төрөл	Шалгуур үзүүлэлт
Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагнал:		
1	Аймгийн “Хүндэт иргэн”	<p>Улс, аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжил, бүтээн байгуулалтанд онцгой хувь нэмэр оруулсан, урлаг, спорт, шинжлэх ухааны салбарт өндөс амжилт гарган тив, дэлхийн хэмжээнд Сэлэнгэ аймгийн нэрийг дуурсгасан ард иргэд, хүүхэд залуусын үлгэрлэх дууриах, хүндэлийг хүлээхүйц ажил амьдралын замналтай, тухайн салбartaа ажил үйлсээрээ манлайлж, хүлээн зөвшөөрөгдсөн Сэлэнгэ аймгийн харьят, тус аймагт удаан хугацаагаар ажиллаж, амьдарч байсан иргэнийг доорх төрөл, шалгуур үзүүлэлтээр дүгнэж шагнана. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">- “Төр, захиргааны салбар”-аасТөр, орон нутгийн захиргааны байгууллагад 25-аас доошгүй жил, удирдах албан тушаалд 15 жил үр бүтээлтэй ажиллаж, улс орны болон аймаг, орон нутгийн эдийн засгийн хөгжил, бүтээн байгуулалтанд үнэтэй хувь нэмэр оруулсан иргэнийг.- “Соёл, урлаг шинжлэх ухааны салбар”-аасУрлаг, уран бүтээл, шинжлэх ухааны судалгаа шинжилгээний нээлтээрээ улс, аймаг, орон нутгийнхаа нэрийг олон улс, тив, дэлхийд алдаршуулж, мэргэжлийн уралдаан, тэмцээнд тэргүүн байр эзэлсэн, Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын зүтгэлтэн, төрийн шагнал хүртсэн иргэнийг.- “Биеийн тамир, спортын салбар”-аасОлимпийн тэмцээнд медаль хүртсэн, дэлхийн аваргын тэмцээнээс олимпийн спортын төрлөөр алт, мөнгө, хүрэл медаль, хошой хүрэл медаль, тивийн аваргын тэмцээнээс олимпийн спортын төрлөөр алтан медаль, хошой мөнгөн медаль хүртсэн, бусад спортын төрлийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс хошой алт, мөнгөн медаль хүртсэн тамирчин, мөн Үндэсний их баяр наадмын үндэсний бөхийн барилдаанд хоёроос доошгүй удаа түрүүлэн “Улсын аварга” цол хүртсэн бөх, үндэсний сурын харвааны нэг төрөлд Улсад хоёроос доошгүй удаа түрүүлсэн харваач, Монгол Улсын “Тод манлай уяач” цол хүртсэн уяач.- “Бүтээн байгуулалт, үйлдвэрлэл, байгаль орчны салбар”-аасӨөрийн санаачилгаар барилга, дэд бүтцийн салбарт томоохон хөрөнгө оруулалт хийж, аймаг орон нутгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан, мөн Сэлэнгэ аймгийг гадаад дотоодод сурталчлан таниулахад нөлөөлөхүйц, бренд үйлдвэрлэл, үйлчилгээг хэрэгжүүлсэн, байгаль орчныг хамгаалах үйлсэд онцгой хувь нэмэр оруулсан иргэдийг.

		<p>- Бусад:</p> <p>Иргэний журамт үүргээ ухамсарлаж, байгалийн гамшигт үзэгдэл, гал усны аюул болон бусад аюултай нөхцөл байдлаас болон мэргэжлийн ур чадвар, хичээл зүтгэлзэрээ олон хүний эрүүл мэнд, амь нас, их хэмжээний өмч хөрөнгийг авран хамгаалсан иргэдийг тус тус шагнана.</p> <p>Мөн Сэлэнгэ аймгийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны салбарт бодитой хувь нэмэр оруулсан гадаадын иргэнийг шагнаж болно.</p>
2	Аймгийн “Хүндэт тэмдэг”	<p>Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үйлсэд онцгой хувь нэмэр оруулан амжилт гаргасан байгууллага, улсад 15-аас доошгүй жил ажилласан иргэнийг шагнана.</p> <p>Сэлэнгэ аймгийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны салбарт бодитой хувь нэмэр сруулсан гадаадын иргэнийг шагнаж болно.</p> <p>Шагналд нэр дэвшигч өмнө нь аймгийн Засаг даргын жуух бичгээр шагнагдсан байна.</p>
3	Аймгийн ИТХ-ын “Хүндэт өргөмжлөл”	<p>Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үйлсэд онцгой хувь нэмэр оруулан амжилт гаргасан байгууллага, улсад 10-аас доошгүй жил ажилласан иргэнийг шагнана.</p> <p>Шагналд нэр дэвшигч өмнө нь аймгийн Засаг даргын жуух бичгээр шагнагдсан байна.</p>
Аймгийн Засаг даргаас олгох шагнал:		
1	Аймгийн Засаг даргын “Жуух бичиг”	Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үйлсэд онцгой хувь нэмэр оруулан амжилт гаргасан, улсад 10-аас доошгүй жил, тухайн байгууллагад 5-аас дээш жил ажилласан иргэнийг шагнана.
2	Аймгийн “Тэргүүний хамт олон”	Төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын бодлого зорилтыг хэрэгжүүлэхэд идэвх санаачилга гаргасан, аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үйлсэд бодитой хувь нэмэр оруулсан байх
		Тухайн жилийн салбарын хэмжээнд дэвшүүлсэн зорилтыг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлсэн, тэргүүн туршлага нэвтрүүлсэн, өрсөлдөхүйц хэмжээний тогтвортой амжилт үзүүлсэн байх
		Байгууллагынхаа гадаад, дотоод орчин нөхцлийг сайжруулахад чиглэсэнхөрөнгөоруулалтхийж, ажиллагсдыннийг насуудлыг тодорхой түвшинд шийдвэрлэсэн байх
3	Аймгийн салбарын “Аварга ажилтан”	Байгууллага, иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээ, санхүүгийн үйл ажиллагааны талаар ямар нэгэн зөрчил дутагдал гаргаагүй байх
		Салбартаа 10-аас дсошгүй жил ажилласан, тухайн жилд ёс зүйн зөрчил дутагдал гаргаагүй байх
		Салбарын хэмжээнд тавигдаж байгаа бодлого зорилтыг хэрэгжүүлэх талаар идэвх санаачилга гарган тодорхой амжилт үзүүлсэн байх
		Төрийн албан хаагчдын хувьд сүүлийн 2 жил дараалтан үйл

		<p>ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээгээр “В” болон түүнээс дээш үнэлгээ авсан, мэргэжлийн өндөр ур чадвартай байх</p> <p>Байгууллага, иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээ, үйл ажиллагааныхаа талаар ямар нэгэн алдаа дутагдал гаргаагүй байх</p> <p>Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний хувьд холбогдох хууль тогтоомжийн дагуу эрүүл мэндийн даатгал, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байх</p>
4	Аймгийн “Аварга малчин”	<p>Мал, амьтныг эрсдэлээс хамгаалах даатгалд хамруулж, малчин өрх, нэхөрлөлийн гишүүд холбогдох хууль тогтоомжийн дагуу эрүүл мэндийн даатгал, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байх</p> <p>Ажлын байрыг нэмэгдүүлэх болон орон нутагтаа ядуурлыг бууруулахад тодорхой хувь нэмэр оруулсан байх</p> <p>Мал сүргээ эрүүл байлгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд өөрийн санаачилгаар оролцдог байх, сумын мал эмнэлэг, үржлийн тасгийн эмчээр мал эмнэлгийн үзлэг хийлгэж хэвшсэн байх</p> <p>Мэргэжлийн байгууллагаас ангилалт хийж удам гарвал, ашиг шимиийг нь тогтоосон, стандартын шаардлага хангасан малыг үржилд ашигладаг, малаа сумын мал эмнэлэг, үржлийн тасгийн бүртгэлд хамруулсан байх</p> <p>Сүүлийн гурван жил дараалан малын зүй бус хорогдол гаргаагүй, нийт сүрэг дэх үхрийн тоо толгойг тогтмол өсгөж сүү, цагаан идээ, мах бэлтгэн зах зээлд нийлүүлсэн байх</p> <p>Сүрэгт эзлэх хээлтэгч мал нь бог малд 55, бод малд 40-өөс доошгүй хувьд хүрсэн, эр, сувай малыг эдийн засгийн эргэлтэд эрт оруулдаг байх</p> <p>Нэг малаас авч байгаа ашиг шим нь тухайн орон нутагт үржүүлж байгаа үүлдэр, омгийн малын ашиг шимиийн дундаж үзүүлэлтээс дээгүүр байх</p> <p>Хонин толгойд шилжүүлснээр нэг малд 50 кг-аас доошгүй өвстэй тэнцэхүйц хадлан, гар тэжээл, таримал тэжээл, өвсөн дарш, хүчит тэжээлийг жил бүр бэлтгэж нөөцөлсөн байх</p> <p>Нутаглаж байгаа өөрийн газрынхаа бэлчээрийн даацаад малын тоог тохируулах, оторхийх, сэлгэн өнжөөх зэргээр бэлчээр хамгаалах арга хэмжээ авдаг байх</p> <p>Өөрийн эзэмшлийн өвөлжөө, хаваржаа, малын хашаатай байх</p> <p>Баталгаажсан үүлдэр, омгийн малаар малынхаа чанарыг сайжруулан эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авсан байх</p> <p>Аймгийн “Малчид тариаланчдын үйл ажиллагааны зохицлыг хангах журам”-ыг хэрэгжүүлж ажилласан байх</p>
5	Аймгийн “Аварга	Байгаль орчинд халгүй аргаар үйл ажиллагаа эрхэлж, орчны ариун цэвэр, эрүүл ахуй, халдвартайжилтийг шийдвэрлэсэн,

	фермер" /хэр, гахай, шувуу, зэгийн аж ахуй эрхлэгч иргэн/	экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөхцөлийг бүрдүүлсэн байх
		Мал, амьтныг эрсдэлээс хамгаалах даатгалд хамруулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу татвар, хураамж, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл тогтмол төлсөн байх
		Мал, амьтныг халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулан эрүүл сүрэгтэй болсон байх
		Мал бүр хувийн дугаартай, үржилд ашиглаж байгаа малын анги, ашиг шимиийн гарц, чанарыг мэргэжлийн байгууллагаар баталгаажуулсан байх
		Үржлийн алба болон хэрэглэгчийн захиалгаар үржлийн мал, гахай, шувуу, зэгий үржүүлж худалдсан байх
		Өөрийн мал маллагааны арга туршлагыг залуу малчдад эзэмшүүлэх талаар санаачилга гарган ажиллаж 3-аас доошгүй ажлын байр бий болгосон байх
6	Аймгийн “Аварга тариаланч хамт олон”	Аж ахуйн нэгж, байгууллага нь газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой эрхэлсэн байх
		Жилбүрүс алгаатай нөхцөлдүртариа, малын тэжээлийн нургамал 250 га, усалгаагүй нөхцөлдүртариа, малын тэжээлийн нургамал 500 га, төмс, хүнснийногоо, жимс, жимсгэнэ 10 га-д тариалсан байх
		Сүүлийн 3 жил дараалан жил бүр га тутмаас хураан авсан үр тарианы ургац нь усалгаагүй талбайд 15 цн-ээс, усалгаатай талбайд 30 цн-ээс, төмсний ургац нь усалгаагүй талбайд 160 цн-ээс, усалгаатай талбайд 200 цн-ээс, малын тэжээлийн ургац нь усалгаагүй талбайд 30 цн-ээс, усалгаатай талбайд 60 цн-ээс доошгүй байх
		Хөрсний үржил шимийг хамгаалах, чийгийн хуримтлалыг нэмэгдүүлэхэд чиглэсэн дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэн, үр тарианы үйлдвэрлэлд уриншийн эзлэх хувийн жинг баагсаж, тэжээлийн ургамлыг сэлгээнд оруулсан байх
		Үр тарианы үйлдвэрлэл эрхлэгчид нь эргэлтийн талбайгаа 100 хувь ашиглаж, дараа оны тариалалтад зориулан хүрэлцэхүйц хэмжээний чанар сайтай үр нөөцөлсөн байх;
		Аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалт хийж, шинээр ажлын байр бий болгох, ажиллагдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд тодорхой хувь нэмэр оруулсан байх
		Татвар, хураамж болон газрын төлбөрийг хугацаанд нь төлсөн байх
		Хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний газартай болж техникийн бэлэн байдал, хангамжийг сайжруулсан байх
7	Аймгийн	“Малчид тариаланчдын үйл ажиллагааны зохицлыг хангах журам”-ыг хэрэгжүүлж ажилласан байх
7	Аймгийн	Газар тариалангийн үйлдвэрлэлд 5-аас дээшжилтогтвортой

	<p>“Аварга тариаланч”</p>	<p>ажилласан байх</p> <p>Сүүлийн 3 жил дараалан жил бүр га тутмаас хураан авсан үр тарианы ургац нь усалгаагүй талбайд 13 цн, усалгаатай талбайд 30 цн-ээс доошгүй байх</p> <p>Сүүлийн 3 жил дараалан жил бүр комбайнаар шууд хураалтад шилжүүлснээр 400 га, трактораар 1200 жишмэл га-гаасдоошгүй ажил гүйцэтгэсэн байх</p> <p>Малын тэжээлийн ургац нь усалгаагүй талбайд 30 цн, усалгаатай талбайд 60 цн-ээс доошгүй байх</p> <p>Техник технологийн бүрэн бүтэн байдлыг хангаж, ашиглалтын явцад эвдрэл гэмтэл гаргалгүй ажиллах, эдийн засгийн хувьд үр ашигтай ажилласан байх</p>
8	<p>Аймгийн “Аварга ногоочин”</p>	<p>Төмс, хүнсний ногоо тариалах үйл ажиллагааг 10-аас дээшжилтогтвортой эрхэлсэн байна;</p> <p>Төмсний ургац нь усалгаагүй талбайд 110 цн, усалгаатай талбайд 200 цн-ээс доошгүй байх</p> <p>Сүүлийн 3 жил дараалан жил бүр га тутмаас 250 цн, үндэс үрт ногоо 120 цн, сонгинолог ургамал 80 цн, хамгаалаадсан хөрсний 1 м.кв талбай тутмаас өргөст хэмх 15 кг, улаан лооль 10 кг-аас доошгүй ургац хураан авсан байх</p> <p>Байгаль орчинд халгүй аргаар үйл ажиллагаа эрхэлж, экологийн цэвэр бүтээгдэхүүн тарьж ургуулах нөхцөлийг бүрдүүлсэн байх</p> <p>Төмс, хүнсний ногоо тариалахад гарч байгаа шинэлэг арга ажиллагааг үйл ажиллагаандaa нэвтрүүлэх талаар тодорхой санаачилга гарган ажилласан байх</p>
		<p>Тухайн жилийн улс, аймгийн баяр наадам, улсын чанартай бүсийн уралдаануудад уяж уралдуулсан морьд нь түрүүлж, айрагдсан уяачдыг амжилтаар нь эрэмбэлэн шалгаруулна.</p>
		<p>1. Сурлагын өндөр амжилт үзүүлсэн сурагч:</p> <p>Хичээлийн жилийн 40-өөс доошгүй улирал дараалан “А” үнэлгээтэй суралцаж байгаа</p>
		<p>Улс, бүсийн хэмжээний төрөлжсөн хичээлийн олимпиадад тогтмол оролцож, эхний 10 байрт шалгарсан байх</p>
		<p>Аймгийн хэмжээний төрөлжсөн хичээлийн олимпиадад тогтмол оролцож, эхний 5 байрт шалгарсан байх</p>
10	<p>Аймгийн “Тэргүүний сурагч”</p>	<p>Өөрийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлж, илтгэл, эссэ бичлэгийн уралдаануудад амжилттай оролцсон байх</p> <p>Сурлага, хүмүүжлээр доголдож байгаа болон буруу хэвшилд орсон найз нөхөддөө дэмжлэг үзүүлж амжилтанд хүргэсэн байх</p> <p>2. Спортын өндөр амжилт үзүүлсэн сурагч:</p> <p>Өсвөрийн тив, дэлхийн аварга шалгаруулах, олон улсын уралдаан тэмцээнүүдэд өндөр амжилт үзүүлж медальт болон шагналт байрт шалгарсан байх.</p> <p>Улс, бүс, аймгийн чанартай спортын уралдаан тэмцээнд хувийн</p>

		<p>болон багийн амжилтаараа 2-оос доошгүй удаа улсад эхний 5 байрт, аймагт эхний 3 байрт шалгарсан байх</p> <p>Өөрийн хичээллэж буй спортын төрлөөр цол, зэрэг хүртсэн байх.</p> <p>3. Урлагийн өндөр амжилт үзүүлсэн сурагч:</p> <p>Олон Улсын хэмжээнд зохиогдог ёсвériйн уран бүтээлчдийн их наадам, уралдаанд амжилттай оролцож медальт болон шагналт байрт шалгарсан байх.</p> <p>Улс, бүсийн болон аймгийн хэмжээнд зохиогдсон урлагийн наадам, уралдаанд оролцож, өндөр амжилт үзүүлсэн.</p> <p>Урлагийн аль нэг төрөл /дуу, хөгжим, язгуур урлаг, яруу найраг гэх мэт/-өөр хичээллэж, уран бүтээлийн тайлан тогтолцт, уран бүтээл /дуу, клип, цомог гэх мэт/ хийж олны хүртээл болгосон байх.</p> <p>Дүрслэх урлаг /уран зураг, баримал, сийлбэр, хатгамал гэх мэт/-ийн аль нэг төрлөөр уран бүтээлийн үзэсгэлэн гаргасан байх.</p>
--	--	---

_____оОо_____

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 11 дүгээр сарын 10-ны
өдрийн 134 дүгээр тогтоодын З.дугаар хавсралт

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГААС ОЛГОХ
ШАГНАЛЫГ ДАГАЛДАХ ЗҮЙЛС, МӨНГӨН ШАГНАЛЫН ХЭМЖЭЭ**

№	Шагналын нэр	Шагналыг дагалдах зүйлс	Мөнгөн шагналын хэмжээ\ төг	
Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгох шагнал				
1	Сэлэнгэ аймгийн "Хүндэт иргэн"	"Хүндэт иргэн"-ий тэмдэг, үнэмлэх, тууз, мөнгөн шагнал	1.0 сая	
2	Сэлэнгэ аймгаас төрөн гарсан алдартнуудын "Нэрэмжит шагнал"-ууд	Өргөмжлөл, мөнгөн шагнал	200.0 мянга	
3	Сэлэнгэ аймгийн "Хүндэт тэмдэг"	Тэмдэг, үнэмлэх, мөнгөн шагнал	30.0 мянга	
4	Аймгийн ИТХ-ын "Хүндэт өргөмжлел"	Өргөмжлөл, мөнгөн шагнал	30.0 мянга	
Аймгийн Засаг даргын шийдвэрээр олгодог шагнал				
5	Аймгийн Засаг даргын "Жуух бичиг"	"Жуух бичиг", мөнгөн шагнал	20.0 мянга	
6	Тухайн оны салбарын аваргууд	Өргөмжлөл, тууз, мөнгөн шагнал	100.0 мянга	
Журмын 2.6-д заасан иргэнд олгох шагнал урамшууллын хэмжээ				
7	Монгол Улсын баатар, Хөдөлмөрийн баатар	Мөнгөн урамшуулал	2.0 сая	
8	Монгол Улсын Ардын цолтон	Мөнгөн урамшуулал	1500.0 мянга	
9	Монгол Улсын Гавьяат цолтон	Мөнгөн урамшуулал	1.0 сая	
10	Монгол Улсын Төрийн шагнал	Мөнгөн урамшуулал	800.0 мянга	
Журмын 2.7-д заасан Спортын тэмцээн уралдаанд амжилттай оролцсон тамирчдад олгох шагнал урамшууллын хэмжээ				
№	Амжилтын чанар	Мөнгөн шагналын хувь хэмжээ	Давтамж	Нөхцөл
Тивийн аварга шалгаруулах тэмцээн, олон улсын "А" зэрэглэлийн тэмцээн				
1	Алтан медаль	Тус тэмцээнд оролцоход тамирчин болон түүний гэр бүлээс гарсан шууд зардлын 70 хүртэлх хувьтай тэнцэхүйц мөнгөн дэмжлэг үзүүлэх	1 удаа	Тус тэмцээнд оролцохдоо аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс <u>дэмжлэг аваагүй тохиолдолд</u>
		Тус тэмцээнд оролцоход тамирчин болон түүний гэр бүлээс гарсан шууд зардлын 50 хүртэлх хувьтай тэнцэхүйц мөнгөн дэмжлэг үзүүлэх	1 удаа	Тус тэмцээнд оролцохдоо аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс <u>дэмжлэг авсан тохиолдолд</u>

2	Мөнгөн медаль	Тус тэмцээнд оролцоход тамирчин болон түүний гэр бүлээс гарсан шууд зардлын 40 хүртэлх хувьтай тэнцэхүйц мөнгөн дүнгээр дэмжлэг үзүүлэх	1 удаа	Тус тэмцээнд оролцохдоо аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс <u>дэмжлэг аваагүй тохиолдолд</u>
		Тус тэмцээнд оролцоход тамирчин болон түүний гэр бүлээс гарсан шууд зардлын 30 хүртэлх хувьтай тэнцэхүйц мөнгөн дэмжлэг үзүүлэх	1 удаа	Тус тэмцээнд оролцохдоо аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс <u>дэмжлэг авсан тохиолдолд</u>
3	Хүрэл медаль	Тус тэмцээнд оролцоход тамирчин болон түүний гэр бүлээс гарсан шууд зардлын 20 хүртэлх хувьтай тэнцэхүйц мөнгөн дэмжлэг үзүүлэх	1 удаа	Тус тэмцээнд оролцохдоо аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс <u>дэмжлэг аваагүй тохиолдолд</u>
		Тус тэмцээнд оролцоход тамирчин болон түүний гэр бүлээс гарсан шууд зардлын 10 хүртэлх хувьтай тэнцэхүйц мөнгөн дэмжлэг үзүүлэх	1 удаа	Тус тэмцээнд оролцохдоо аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс <u>дэмжлэг авсан тохиолдолд</u>
Олимп, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн				
1	Алтан медаль	Тус тэмцээнд оролцоход тамирчин болон түүний гэр бүлээс гарсан шууд зардлын 90 хүртэлх хувьтай тэнцэхүйц мөнгөн дэмжлэг үзүүлэх	1 удаа	Орон нутгаас хөрөнгийн <u>дэмжлэг аваагүй тохиолдполд</u>
		Тус тэмцээнд оролцоход тамирчин болон түүний гэр бүлээс гарсан шууд зардлын 70 хүртэлх хувьтай тэнцэхүйц мөнгөн дэмжлэг үзүүлэх	1 удаа	Орон нутгаас хөрөнгийн <u>дэмжлэг авсан тохиолдполд</u>
2	Мөнгөн медаль	Тус тэмцээнд оролцоход тамирчин болон түүний гэр бүлээс гарсан шууд зардлын 60 хүртэлх хувьтай тэнцэхүйц мөнгөн дүнгээр үзүүлэх	1 удаа	Орон нутгаас хөрөнгийн <u>дэмжлэг аваагүй тохиолдполд</u>
		Тус тэмцээнд оролцоход тамирчин болон түүний гэр бүлээс гарсан шууд зардлын 50 хүртэлх хувьтай тэнцэхүйц мөнгөн дэмжлэг үзүүлэх	1 удаа	Орон нутгаас хөрөнгийн <u>дэмжлэг авсан тохиолдполд</u>
3	Хүрэл медаль	Тус тэмцээнд оролцоход тамирчин болон түүний гэр бүлээс гарсан шууд зардлын 40 хүртэлх хувьтай тэнцэхүйц мөнгөн дэмжлэг үзүүлэх	1 удаа	Орон нутгаас хөрөнгийн <u>дэмжлэг аваагүй тохиолдполд</u>

		Тус тэмцээнд оролцоход тамирчин болон түүний гэр бүлээс гарсан шууд зардлын 30 хүртэлх хувьтай тэнцэхүйц мөнгөн дэмжлэг үзүүлэх.	1 удаа	Орон нутгаас хөрөнгийн <u>дэмжлэг авсан тохиолдполд</u>
--	--	--	--------	---

—сОо—

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 11 дүгээр сарын 10-ны
өдрийн 134 дүгээр төгтоолын 4 дүгээр хавсралт

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН
ШАГНАЛААР ШАГНУУЛАХ ХҮНИЙ АНКЕТ**

- 1.Овог, нэр:
- 2.Регистрийн дугаар:
- 3.Төрсөн он, сар, өдөр:
- 4.Хүйс:
- 5.Үндсэн захиргаа:
- 6.Яс үндэс:

--

- 7.Ажил эрхэлсэн байдал /он дарааллаар/:

№	Байгууллагын нэр	Ажилласан хугацаа	Эрхэлж байсан албан тушаал

- 8.Шагнагдаж байсан шагналууд:

№	Шагналын нэр	Шагнагдсан он

- 9.Шагнуулах үндэслэл:

- 10.Шагнуулах шагналын нэр:

- 11.Хамт олны саналын хувь:

Байгууллагын дарга, захирал, эрхлэгчийн нэр, гарын үсэг, тамга

Огноо: